

# **САНГИЙН ЯАМНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

## **НЭГ. ЗОРИЛГО**

Монгол Улсын Сангийн яам нь төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх ажлын хүрээнд “Ирээдүйгээ төсөвлө” аяныг 2021 оноос эхлэн хэрэгжүүлж, цуврал контент, подкаст, онлайн хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал болон хакатон зэрэг арга хэмжээнүүдийг үр дүнтэй зохион байгуулсан.

Энэ жил мөн төсөв санхүү, эдийн засгийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийдэг оюутан, судлаач, эрдэмтдийг дэмжих, бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, төсөв батлагдах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн бодлого боловсруулалтад оролцох оролцоог нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хурлыг 3 дахь удаагаа зохион байгуулахад бэлэн болоод байна.

## **ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ**

Оюутнууд болон эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төв, төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, бизнесийн байгууллагын эрдэм шинжилгээний ажилтан, судлаач багш нар.

## **ГУРАВ. СЭДВИЙН ЧИГЛЭЛ**

Эрдэм шинжилгээний хуралд оролцож буй оюутан, судлаачид төсөв, сангийн бодлогын чиглэлээр өөрийн сонирхож буй сэдвээр судалгааны ажил хийх боломжтой бөгөөд дараах жишиг сэдвийн чиглэлээр хязгаарлагдах шаардлагагүйг анхаарна уу.

- 3.1 Далд эдийн засгийг хэмжих, түүнийг төсвийн бодлогын нөлөөллөөр бууруулах арга зам
- 3.2 Орон нутгийн хөгжил болон төсвийн хуваарилалт
- 3.3 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж болон түүний эдийн засгийн хөгжлийг дэмжих нь
- 3.4 Төсвийн зардал ба үр ашгийн шинжилгээ

- 3.5 Засгийн газрын өрийн бүтцийн дүн шинжилгээ, төсөвт үзүүлэх дарамтын тооцох нь
- 3.6 Төсвийн эрсдэл, түүний нөлөөг хэмжих арга зам
- 3.7 Төсвийн тогтвортой байдлыг шинжих нь
- 3.8 Бүсчилсэн байдлаар хөгжихөд төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөө
- 3.9 Төсвийн зардлын инфляц, төлбөрийн тэнцэл болон бусад макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөө
- 3.10 Тогтвортой хөгжлийн зорилтод төсвийн бодлогоор хүрэх арга зам: *Төсвийн зарцуулалтад жендэрийн дүн шинжилгээ хийх* нь

## **ДӨРӨВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

### 4.1 Бүтээлийн агуулгын хувьд:

- Онол, арга зүйн үндэслэлтэй;
- Шинэлэг, оновчтой санал, санаачлага;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц;
- Эконометрик, статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан;
- Оюутны ангилалд оролцох судалгааны ажлууд уждирдагч багштай байх;
- Бусдын ажлыг шууд хуулбарлаагүй;
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан;
- Судалгааны шалгарсан болон шинэлэг арга хэрэгслүүдийг ашигласан байх;
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжид хүрсэн байх.

### 3.2 Оролцогчдын хувьд:

- Оролцогч нь оюутны болон судлаачийн аль ангилалд оролцохоо тодорхой бичих;
- Дотоодын болон гадаадын их дээд сургуулийн 2 ба түүнээс дээш курсийн оюутан байх;
- Судлаачийн ангилалд оролцогч нь эрхэлж буй ажил албан тушаал, мэргэжлээ тодорхой дурдах;
- Багаар оролцож болох ба гишүүдийн тоо 5-аас ихгүй байна;
- Бүтээлээ цахим шуудангаар ирүүлнэ.

### 3.3 Бичгийн стандарт:

- Үсгийн фонт – Times New Roman /”Mon” өргөтгөлтэй фонт байж болохгүй/;
- Фонтын хэмжээ - 12;
- Мөр хоорондын зай – 1,5;
- Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;
- Цаасны хэмжээ: А4
- Товч мэдээлэл: Сэдвийн хүрээнд өөрийн судалгааны хураангуйг бичсэн байх;
- Бусад: Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих;
- Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Илтгэл нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт ном зүй гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах).

## **ДӨРӨВ. ХУРЛЫН ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАХ**

- 5.1 **Нэгдүгээр шат:** Зохион байгуулах комисс бүтээлийг файл хэлбэрээр 2024 оны 05 дугаар сарын 8-ны өдөр хүлээн авч, 2024 оны 05 дугаар сарын 10-аас 13-ны өдрүүдэд бүтээлийг дүгнэж, сонгон шалгаруулалтад тэнцсэн оролцогчдод мэдэгдэнэ.
- 5.2 Сонгон шалгаруулалтад тэнцсэн, “**оюутны ангилалд**” оролцож буй оролцогчдод зохион байгуулах комиссоос 2024 оны 5 дугаар сарын 14-өөс 17-ны өдрүүдэд ментор томилж, тогтсон цагийн хуваарийн дагуу судалгааны ажилд зөвлөгөө өгнө.
- 5.3 **Хоёрдугаар шат:** 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр нэгдсэн хуралдаан болох бөгөөд Сангийн яам болон гадны төлөөлөгч нараас бүрдсэн багаар шүүлгэн дүнг гаргаж, шалгарсан бүтээлүүдийг Сангийн яамны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээнэ.
- 5.4 Эцсийн шатад шалгарсан бүтээлүүдийн хэлэлцүүлэгт тавигдах шаардлага
  - Илтгэлийг Powerpoint эсвэл PDF файлын хураангуйтай хамт ирүүлэх;

- Илтгэл нь гарчиг, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Илтгэл сэдвийн хүрээнд байгаа эсэх;
- Шинэлэг санаа гаргасан байдал;
- Илтгэх чадвар;
- Санаагаа тодорхой хүргэх чадвар (ойлгомжтой, цэгцтэй);
- Асуултад оновчтой хариулж буй байдал;
- Үгийн сонголт, ярианы чадвар;
- Илтгэлийн хугацаа: 10 минут.

## **ТАВ. ШАГНАЛЫН САН**

### 6.1 Оюутны ангилал

- 1-р байр – Өргөмжлөл, 1 800 000 /Нэг сая найман зуун мянган төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 1 500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 1 200 000 /Нэг сая хоёр зуун мянган төгрөг/

### 6.2 Судлаачийн ангилал

- 1-р байр – Өргөмжлөл, 2 500 000 /Хоёр сая таван зуун мянган төгрөг/
- 2-р байр – Өргөмжлөл, 2 000 000 /Хоёр сая төгрөг/
- 3-р байр – Өргөмжлөл, 1 500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/

## **ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ**

Хугацаа: 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 18:00 цаг хүртэл бүтээлийг электрон хэлбэрээр [bodiragchaab@mof.gov.mn](mailto:bodiragchaab@mof.gov.mn) хаягаар хүлээн авна.

Судалгааны бүтээлийг цахим шуудангаар ирүүлэхдээ оролцогчийн мэдээлэл (нэр, холбоо барих мэдээлэл, цахим шуудан), сургуулийн болон байгууллагын нэр, удирдагч багшийн мэдээлэл болон судалгааны бүтээлийн нэрийг тодорхой бичиж илгээхийг анхаарна уу.